

Батлав.

БОАЖЯ-ны Хүрээлэн Буй Орчин  
Байгалийн Нөөцийн Удирдагын газрын дарга

Ц.Уранчимэг



Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн

ЦЭЭГ ХХК-ийн захирал

Л.Цэрэндорж

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН НУТАГ ДЭВСГЭР  
ХӨВСГӨЛИЙН БЦГ-ЫН ОНГОЛОГИЙН ЦАГААН ДЭНЖ НЭРТЭЙ ГАЗАРТ БАЙРЛАХ  
“ГУРВАН-ЭРДЭНЭ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2615843/

Хянасан:

БОАЖЯ-ны Хүрээлэн Буй Орчин  
Байгалийн Нөөцийн Удирдагын газрын мэргэжилтэн

П.Шинэцэцэг

Боловсруулсан:

“Гурван-Эрдэнэ” жуулчны баазын менежер

Ц.Мянган-Эрдэнэ

2022 он

## **Агуулга**

<b>1. Товч танилцуулга .....</b>	<b>4</b>
<b>2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт .....</b>	<b>18</b>
2.1. Төслийн талбай, түүний орчны байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт .....	18
2.2. Төслийн талбай, түүний орчны нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	23
<b>3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....</b>	<b>24</b>
<b>4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт ....</b>	<b>27</b>
<b>5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....</b>	<b>29</b>
<b>6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....</b>	<b>31</b>
<b>7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээнийн төлөвлөгөө .....</b>	<b>32</b>
<b>8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....</b>	<b>32</b>
<b>9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....</b>	<b>33</b>
<b>10. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....</b>	<b>36</b>
<b>11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах хуваарь .....</b>	<b>37</b>

## **Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Ашиглаж буй газрын булангийн эргэлтийн цэгүүд.....	4
Хүснэгт 2. Барилга байгууламжийн жагсаалт .....	7
Хүснэгт 3. Ус ашиглалтын тооцоо (А/301 тоот нормоор) .....	15
Хүснэгт 4. Усны химийн задлан шинжилгээний дүн (Жуулчны баазын ус нөөцлөх сав) .....	20
Хүснэгт 5. Усны химийн задлан шинжилгээний дүн (Хөвсгөл нуурын ус) .....	20
Хүснэгт 6. Хөрсний агрохимийн үзүүлэлт.....	21
Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн .....	21
Хүснэгт 8. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл.....	25
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	29
Хүснэгт 10. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....	31
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	32
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	33
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	36
Хүснэгт 14. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь .....	37
Хүснэгт 15. 2022 оны БОМТ-нд зарцуулагдах нийт зардал, төгрөг.....	38

## **Зургийн жагсаалт**

Зураг 1. Жуулчны баазын байршил .....	5
Зураг 2. Жуулчны баазын харагдах байдал .....	6
Зураг 3. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт .....	7
Зураг 4. Жуулчны баазын ерөнхий зохион байгуулалт .....	9
Зураг 5. Ресторан .....	10

Зураг 6.	Амралтын том байшин.....	10
Зураг 7.	Амралтын жижиг байшин.....	10
Зураг 8.	Жуулчны урц.....	11
Зураг 9.	Жуулчны гэр сууц.....	11
Зураг 10.	Ариун цэврийн байгууламж.....	11
Зураг 11.	Эко ариун цэврийн байгууламж.....	11
Зураг 12.	Ажилчдын байр.....	11
Зураг 13.	Үйлчилгээний шат дамжлага.....	12
Зураг 14.	Дэд станц.....	13
Зураг 15.	Ус татах насос загвар.....	13
Зураг 16.	Зөөврийн шүршүүр.....	13
Зураг 17.	Шинэчлэсэн ус ашиглах гэрээ.....	14
Зураг 18.	Цэвэр усны төлбөрийн баримт.....	15
Зураг 19.	Шинэчлэсэн хог хаягдлын гэрээ.....	16
Зураг 20.	Бохир усны цооног.....	17
Зураг 21.	Бохир ус дамжуулах хоолой.....	17
Зураг 22.	Дээжлэлт хийх цэгийн байршил.....	35

## 1. Товч танилцуулга

**Төслийн нэр:** “Гурван - Эрдэнэ” жуулчны бааз

**Төсөл хэрэгжүүлэгч:** “ЦЭЭГ” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011012058  
Регистрийн дугаар: 2615843  
Хаяг: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 3-р хороо  
Утас: 976-99107981; 11-320-320  
Факс: 7606-7696  
Веб сайт: [www.inktop.mn](http://www.inktop.mn)  
Цахим шуудан: [tseegservice@yahoo.com](mailto:tseegservice@yahoo.com)


**Төслийн үргэлжлэх хугацаа:** 2013 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

**Төслийн зорилго:** Экологи, газарзүйн хувьд онцгой ач холбогдолтой байгалийн аялал жуулчлалын томоохон бүс болох Хөвсгөлийн БЦГ-ыг түшиглэн гадаад, дотоодын аялагч жуулчдын амрах таатай орчинг бүрдүүлэн, экосистемийг сурталчилан таниулж, үндэсний болон олон улсын түвшинд нийцсэн, нийгэм эдийн засгийн хувьд үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ тогтвортой аялал жуулчлалын нэг хэлбэр болох Нутгийн Иргэдэд Түшиглэсэн Аялал Жуулчлал (НИТАЖ)-ыг хөгжүүлэхэд төслийн гол зорилго оршино.

**Төсөл хэрэгжиж буй талбайн байршил:** “Гурван - Эрдэнэ” жуулчны бааз нь Засаг захиргааны хувьд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэр, Хөвсгөлийн БЦГ-ын Онгологийн цагаан дэнж нэртэй газарт, Хөвсгөл нуурын баруун эрэгт байрлана.

Хүснэгт 1. Ашиглаж буй газрын булангийн эргэлтийн цэгүүд

	Талбайн булангийн эргэлтийн цэгүүд	Х, өргөрөг			Ү, уртраг		
		гра	мин	сек	гра	мин	сек
Газар ашиглах 2016/476 тоот гэрчилгээний хавсралтаар 2.23 га	1-2	100	14	37.000	50	43	30.800
	2-3	100	14	34.900	50	43	32.500
	3-4	100	14	38.000	50	43	34.100
	4-5	100	14	45.000	50	43	38.000
	5-6	100	14	46.000	50	43	35.900
	6-7	100	14	46.500	50	43	34.500
	7-8	100	14	45.700	50	43	33.300
	8-9	100	14	40.700	50	43	32.100



Зураг 1. Жуулчны баазын байршил





Зураг 2. Жуулчны баазын харагдах байдал

Газар ашигласны төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж, газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг орон нутгаас гаргуулан төлбөрийн үлдэгдэлгүй байна. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг дараагийн хуудаст хавсаргав.

Газрын төлбөрт жил бүр 333 165 төгрөг тушаадаг.

**ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТООЦОО НИЙЛСЭН АКТ**  
№06704-2016/00070

Огноо 2022-09-19

Эрх зүйн харилцааны мэдээлэл

Засаг даргын шийдвэрийн огноо: 2016-07-21, 06704-201/2016  
Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний дугаар: 06704-2016/00070

Газар эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн нэр: Цээг ХХК  
Регистрийн дугаар: 2515843  
Нэгж талбарын дугаар, гэрчилгээний дугаар: 6714002581.476

Газрын улсын бүртгэлийн дугаар: 2-р баг Онголог гол 3, Аялал, жуулчлалын-бааз  
Газрын байршил, зориулалт: 99107981  
Утасны дугаар: 22211  
Талбайн хэмжээ: 333165  
Газрын жилийн төлбөр: 5  
Газар эзэмших хугацаа: 5

Газрын төлбөр төлсөн №	Төлбөр тооцсон хугацаа /он/	Байдлыг хүснэгтээр үзүүлэв Нөхөн төлбөр алданги, торгууль /төг/	Тухайн онд төлөх төлбөр /төг/	Нийт төлөх төлбөр /төг/	Төлсөн төлбөр /төг/	Төлбөрийн үлдэгдэл /төг/
1	2020	0	333164	333164	333164	0
2	2021	0	333165	333165	333165	0
3	2022	0	333164	333164	333164	0
	Дүн	0	333164	999493	999493	0

2022-12-31-ний өдрийг хүртэл газрын төлбөрийн үлдэгдэл 0 төгрөг байна.  
Газрын төлбөрөө нэхэмжлэхийн дагуу хугацаанд нь төлнө үү.

ТООЦОО НИЙЛСЭН Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын  
Газрын даамал /П Нямдорж/  
Зөвшөөрсөн /Цээг ХХК/  
Хянасан ТУБ /Р Энхцэцэг/

Зураг 3. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт

**Төслийн хүчин чадал:** Манай Гурван – Эрдэнэ жуулчны бааз нь нэг ээлжиндээ 85-90 жуулчин хүлээн авах хүчин чадалтай, улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг.

Жуулчны баазын талбайд нийт ресторан – 1, амрагчдын байр – 14, амрагчдын урц – 5, Монгол гэр – 10 болон бусад тохижилтын барилга байгууламж байна. Үүнд: ариун цэврийн байгууламж, саравч, тоглоомын талбай зэрэг байна.

Хүснэгт 2. Барилга байгууламжийн жагсаалт

Д/д	Барилга байгууламж	Тоо, ширхэг
1.	Ресторан	1
2.	Урц	5
3.	Гэр сууц	10
4.	Том байшин	6
5.	Жижиг байшин	8
6.	3 хүний душ	1
7.	4 хүний эко жорлон	1
8.	Сагсан бөмбөгийн талбай	1
9.	Гар бөмбөгийн талбай	1

10.	Ширээний теннис	1
11.	Билльярд	1
12.	Карaoke	1
13.	Хүүхдийн усан сан	1
14.	Хүүхдийн тоглоомын талбай	1
15.	Бүжиг, семинарийн танхим	1
16.	Гадаа саравч	15
17.	Нийтийн том саравч	2







Зураг 4. Жуулчны баазын ерөнхий зохион байгуулалт





Зураг 5. Ресторан



Зураг 6. Амралтын том байшин




Зураг 7. Амралтын жижиг байшин



Зураг 8. Жуулчны урц



Зураг 9. Жуулчны гэр сууц




Зураг 10. Ариун цэврийн байгууламж

Зураг 11. Эко ариун цэврийн байгууламж



Зураг 12. Ажилчдын байр

**Үйл ажиллагаа.** Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний шат дамжлагууд:



Зураг 13. Үйлчилгээний шат дамжлага

Жуулчид: Нислэг, Гадаад орны жуулчид ирэх

Хүлээн авалт: Хөтөч – орчуулагчид жуулчдыг

- Нисэх онгоцны буудал
- Галт тэрэгний буудал
- Монгол Улсын хилийн боомтоос тосох үйлчилгээг үзүүлнэ.

Улаанбаатар хот орчим болон зам дагуух зүйлийг танилцуулах

Зочид буудал болон өөрийн жуулчны баазад байрлуулах

- Тээврийн хэрэгслийн үйлчилгээ
- Хоол
- Амрах өрөө болон гэр буудал
- Өрөөний үйлчилгээ
- Маршрут үйлчилгээ
- Үзвэр үйлчилгээ
- Бусад үйлчилгээ

Аялал: Манай жуулчны бааз нь дараах аяллын хөтөлбөрүүдээр үйлчилдэг болно.

Үүнд:

- Морин аялал
- Усан онгоц болон моторт завиар
- Аялах аялал
- Явган аялал
- Цаатан айлд зочлох, цаа буга унуулах аялал

Үдэлт: Жуулчны баазаас жуулчдыг үдэх үйл ажиллагаа

Мөрөн хотод өдрийн хоол - Мөрөн нисэх онгоцны буудлаас Улаанбаатар хотруу нисэх

Улаанбаатар хотын аялал (Сүхбаатарын талбай, Үндэсний түүхийн музей, Зайсан толгой зэрэг)



### Дэд бүтэц


Зам харилцаа: Манай Гурван-Эрдэнэ жуулчны бааз нь Улаанбаатар хотоос 845 км, Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумаас 145 км хатуу хучилттай замаар, Хатгал тосгоноос 45 км шороон замаар холбогддог байсан бөгөөд цаашид Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 2 км хучилттай авто зам ашиглалтанд ороход жуулчны бааз хүртэл бүрэн хатуу хучилттай замаар холбогдож байна.

Цахилгаан хангамж: Гадна цахилгааны шугам, дэд станцыг 2020 онд “Зоос Хайрхан” ХХК-иар бариулж, нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон.



Зураг 14. Дэд станц

Ус хангамж: Цэвэр усыг Хөвсгөл нуураас 40 мм диаметртэй 260 м урт зэвэрдэггүй цайран ган трубагаар татаж 0.5 тоннын багтаамжтай 2 ширхэг ус нөөцлөх сав, 1 тн-ийн багтаамжтай 2 ширхэг ус нөөцлөх саванд хуримтлуулан ашиглаж байна.





Зураг 15. Ус татах насос загвар



Зураг 16. Зөөврийн шүршүүр

Ус ашиглах гэрээг орон нутагтай шинэчлэн байгуулав. Гэрээний хуулбарыг доор оруулав.



Зураг 17. Шинэчлэсэн ус ашиглах гэрээ

Үйл ажиллагааны явцад цэвэр усыг унд ахуй, үйлчилгээ (хоол бэлтгэл, угаалга цэвэрлэгээ, халуун ус, бие засах газар) зориулалтаар ашигладаг. Хөвсгөл аймгийн БОАЖГ-ын 2019 оны 06-р сарын 21-ний өдрийн 2019/06-06 дугаартай Ус ашиглуулах дүгнэлтэд зааснаар хоногт 19.2 шоо.метр ус ашигладаг.

Ус ашигласны төлбөрт нийт  $90.4 \text{ төг} \times 19.2 \text{ м}^3 \times 65 \text{ хоног} = 112840$  төгрөг тушааж байна.

Цэвэр ус ашигласны төлбөрийг бүрэн төлж барагдуулсан бөгөөд төлбөрийн баримтыг дараагийн хуудаг оруулав.

*цэвэр усны төлбөр.*

[ ] [ ] [ ]

**ГОЛОМТ БАНК**  
*Сайн саймны санхүүжилт*

**ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ/DEPOSIT SLIP**

Дансны дугаар / Account number: <b>1220128536961</b>	Мөнгөн дүн / Amount: <b>112840</b>	Утас / Phone No: <b>99107981</b>
Тэмдэглэл / Note: (Дансны нэр, Банкны нэр, Гүйлгээний утга) <b>MTA</b>	Валютын нэгж / Currency: <input checked="" type="checkbox"/> MNT <input type="checkbox"/> USD <input type="checkbox"/> CNY <input type="checkbox"/> EUR <input type="checkbox"/> RUB <input type="checkbox"/> JPY	Регистр № / ID No: <b>Р1055092711</b>
Огноо / Date: 2022 9 19	Салбар / Branch: 363 UFC	Харилцагчийн гарын үсэг / Customers signature <i>[Signature]</i>
Гүйлгээний дугаар / Transaction No: GB31719	Банкны нэр / Bank name: ГОЛОМТ БАНК	
Дансны дугаар / Account number: 1165117377	Данс эзэмшигчийн нэр / Account holder: MTA.TATVAR	Энэ баримтанд бичигдсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцаж гарын үсгээр баталгаажуулав. /I, hereby, sign to confirm the accuracy of the information provided here /
Гүйлгээний дүн / Transaction amount: =112,840.00=	Валютын нэгж / Currency: MNT	
Гүйлгээний хураамж / Fee:		
Мөнгөн дүн үсгээр / Amount in words: (НЭГ ЗУУН АРВАН ХОЁР МЯНГА НАЙМАН ЗУУН ДЕЧИН ТӨГРӨГ)		
Гүйлгээний утга / Description: ХЯНАСАН / Reviewed: 1220128536961	ХЯА / Teller: 50001061946; 2615843;	
		Давсгарт / Denomination
		Тоо / Quantity
		10
		20
		50
		100
		500
		1,000
		5,000
		10,000
		20,000
		Бүрд / Total

Зураг 18. Цэвэр усны төлбөрийн баримт

Хүснэгт 3. Ус ашиглалтын тооцоо (А/301 тоот нормоор)

№	Ус хэрэглээний төрөл	Усны хувийн норм, л/хоног	Нэг ээлжинд хүчин чадал, хүн	Усны тоо хэмжээ, м³/хон	
				ХОНОГТ	
1.	Жуулны баазын ус хэрэглээ	180	80	14400л	14.4м³
2.	Зоогийн газрын ус хэрэглээ	25	65x3	4800л	4.8м³
<b>Нийт ус хэрэглээ</b>				<b>19200л</b>	<b>19.2м³</b>

**Тайлбар:** БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-301 тоот тушаалын 14-р хавсралтаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм" -ын дагуу Дундын ариун цэврийн өрөөтэй жуулчны бааз, жуулчин **180 л/хоног**, зоогийн газар **25 л/хоног** тус тус тооцов. /аялал жуулчлалын идэвхтэй ажиллах хугацаа **65 хоног**/

**Хог хаягдал:** Жуулчны баазын үйл ажиллагааны явцад хатуу, шингэн хаягдал гарна.

**Хатуу хог хаягдал:** Хатуу хог хаягдлын дийлэнх хувийг хоол хүнсний хаягдал, сав, баглаа боодол эзэлнэ. Энгийн хатуу хатуу хог хаягдлыг жуулчны баазын талбайд хог

хаягдал түр хадгалах цэгт хуримтлуулан Хүн - байгаль бүлгийн ахлагч Ж.Сайнбаяртай "Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ"-ний дагуу графикайн дагуу зайлуулж байна. Хог хаягдлыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны нэгдсэн хогийн цэгт зайлуулж байна.

Үйл ажиллагааны явцад нийт 3 удаа хог зөөж, 380 000 мян.төг зарцуулсан. Жуулчны баазын хогийг ангилан ялгах, ачиж, зайлуулах ажилд орон тооны 1 хүн ажиллуулав. Ажлын байрыг орон нутгийн ажилгүй иргэдээс хангасан. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 1 гэр бүлийн хүнийг хатуу, шингэн хаягдал зайлуулах ажлыг хариуцуулсан.

Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хамтран ажиллах гэрээг 2022 оны 06 сарын 16-ний өдөр шинэчлэн байгуулав.

ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,  
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр № 5

Нэг: Нийтлэг үндэслэл  
1.1 Энэхүү гэрээний зорилго нь Хөвсгөлийн Байгалийн Цогцолборт Газрын үзэсгэлэнт байгалийг цэвэр ариун байлгах, хог хаягдлыг орчин бүрдүүлэх, хатуу хог хаягдлыг цэвэрлэх ангилан ялгагч хийж, тээвэрлэх хогийн нэгдсэн цэгт хаях, бүртгэлжүүлэх, хяналт тавих, гадаад дотоодын аялагч, амрагчдын тав тухай хангах, таатай орчин бүрдүүлэх, эмх цэгцтэй байлгахад оршино.  
1.2 Энэ гэрээний эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын Байгаль Орчныг Хамгаалах тухай хууль, Монгол Улсын Тусгай Хамгаалалттай Газар нутгийн тухай хууль, Монгол улсын Усны тухай хууль, Монгол Улсын Ахуйн болон Үйлдвэрийн хог хаягдлын тухай хуулийн тодорхой заалтууд болно.

Хоёр: Гэрээ байгуулагч талууд  
Нэг талас: /Захиалагч/ ХХК-ны жуулчны баазын захирал Хөвсгөл овогтой Батбаяр  
Төрөл: Гурван-Эрдэнэ

Нөгөө талас: /Гүйцэтгэгч/ Хүн байгаль бүлгийн ахлагч Жамсран овогтой Сайнбаяр /Хог хаягдал орон нийтийн байцаагч нар харицан тохиролцооны дагуу энэхүү гэрээг байгуулав.

Гурав: Захиалагчийн эрх, үүрэг  
3.1 Хог хаягдлын үйлчилгээний сантай байна.  
3.2 Өөрийн баазын ойролцоох 500 метр хүртэл газар нутгийн хог хаягдлыг цэвэрлэн хяналт тавих.  
3.3 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн барилга барих, буулгах, засварлах тохиолдолд гарах хог хаягдлыг хаях талаар урьдчилан гэрээ байгуулан зохиц төлбөрийг төлсний дараа хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлнэ.  
3.4 Ашиглаж буй талбай түүний ойролцоо зохих зөвшөөрөлгүй хаясан хог хаягдлыг зайлуулж, тээвэрлэх, хөрсийг цэвэршүүлэх, бүртгэл хөтлөх.  
3.5 Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас тогтоосон тарифийн дагуу төлбөрөө бүрэн талж байх.  
3.6 Хориггүйнээс, асууль болгох, саварчлалуулах засалыг мөхлөн төсөвт тусгах.  
3.7 Асуультай хог хаягдлыг ялгаж битүүжилж ачуулах /төрөл бүрийн батерэй, аккумулятор, газын болсон, асаагуур гэх мэт/.  
3.8 Ажилтнуудын эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллыг сахиулах.  
3.9 Нийтийн хамарсан хог хаягдал цэвэрлэх ажилд идэвхитэй оролцох.  
3.10 Хог хаягдлын нэгдсэн цэгтэй байх ба хог хаягдлыг ангилан ялгах савтай байна.  
3.11 Хог хаягдлыг шатааж агаарын бохирдол үүсгэхгүй байх.  
3.12 Гэрээний дагуу хийгдсэн ажилва эрх бүхий байгууллагад тайлагнах.

9910398/  
885079/87

Дөрөв: Гүйцэтгэгчийн эрх, үүрэг  
4.1 Гэрээ байгуулсан захиалагчийн хог хаягдлыг орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас тогтоосон тариф, Улсын Тусгай Хамгаалалттай Газрын байгаль хамгаалагч нар хяналт тавих, ангилан ялгагч хийлгэх гэрээний дагуу хогийн цэгт хүргэж хог тээвэрлэлтийн хүчнэгт хөтлөх.  
4.2 Хог хаягдлаа ачуулаагүй захиалагчийг Улсын Тусгай Хамгаалалттай Газрын байгаль хамгаалагч, Улсын байцаагч нартай хамтран хуулийн дагуу хариуцлага тооцох ба хог тээвэрлэлтийг графикайн дагуу хийнэ.  
4.3 Захиалагчийн ойролцоох 500 метр талбай дахь ой, нуурын дагуух гарсан хог хаягдлыг гэрээний дагуу хариуцуулан цэвэрлүүлж, тээвэрлэх.  
4.4 Өөрийн унаагаар хог хаягдлыг тээвэрлэх, засвар үйлчилгээ, салбег хэрэгсэл, гэмтлийг хариуцан, тээвэрлэлтийн менежментийн асуудлыг шийдвэрлэнэ.  
4.5 Битүүжилсэн асуутай хог хаягдлыг Мэргэжлийн хяналтын газар, Хатгал тосгоны эрүүл ахуйн улсын байцаагчид хүлээлгэн өгнө.  
4.6 Монгол Улсын Байгаль Орчныг Хамгаалах тухай хууль, Монгол Улсын Тусгай Хамгаалалттай Газар нутгийн тухай хууль, Монгол улсын Усны тухай хууль, Монгол Улсын Ахуйн болон Үйлдвэрийн хог хаягдлын тухай хуулийн талаар ухууллага сурталчилгааг хийнэ.

Тав: Гэрээгээс үүсэх хариуцлага  
5.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.  
5.2 Гэрээний хугацаа талууд гарын үсэг зурсан өдөрөөс эхлэн нэг жилийн хугацаатай байна.  
5.3 Тухайн үед гэрээнд тусгагдсангүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.  
5.4 Энэхүү гэрээ нь хугацаа дууссан, эсхүл Иргэний хуулийн 355-р зүйл болон хуульд заасан бусад үндэслэлээр дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧ: ГҮЙЦЭТГЭГЧ

ХХК-ны жуулчны баазын захирал Хөвсгөл овогтой Батбаяр ахлагч Жамсран овогтой Сайнбаяр


"Хүн байгаль" бүлгийн ахлагч Жамсран овогтой Сайнбаяр

Зураг 19. Шинэчлэсэн хог хаягдлын гэрээ

Манай Гурван – Эрдэнэ жуулчны бааз нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жуулчны баазын дээд хүчин чадлаар хоногт гарах хог хаягдлын хэмжээг тооцож үзвэл 50 кг/хон, 1.5 тн/сар, 4.5 тн/жил хатуу хог хаягдал гарна. (хоногт дунджаар 1 хүнээс 0.5 кг хатуу хог хаягдал гарна гэж үзэв.)

Шингэн хаягдал (ахуйн бохир ус): Жуулчны баазын талбайд ариун цэврийн байгууламж болон хоолны газрын бохир усыг цуглуулах 5 м<sup>3</sup>-ын багтаамжтай металл сав, шинээр 4.5 м<sup>3</sup>-ын багтаамжтай металл сав-цооногийг шинээр суурилуулсан.





Зураг 20. Бохир усны цооног



Зураг 21. Бохир ус дамжуулах хоолой



Жуулчны баазын үйл ажиллагаанаас гарах бохир усыг бохирын цооногт түр хуримтлуулан “Байгаль Эрхэс” ХХК-ийн Олимп жуулчны баазтай хийсэн “Бохир ус зайлуулах гэрээ”-ний дагуу зайлуулж, бүртгэлжүүлэн хяналтын хуудас хөтлөн ажилласан.

2022 оны үйл ажиллагааны явцад нийт 7 удаа, 35 тн бохир зайлуулж, үүнд 1950 000 төг зарцуулсан болно. Одоогийн байдлаар Хатгал тосгоны Харганы амны цэвэрлэх байгууламж руу нийлүүлдэг.

Хоолны газрын бохир усыг дамжуулах хоолойг ил болон далд байдлаар хийсэн бөгөөд ил байрлах хуванцар хоолой дээгүүр модон хучилт хийж хамгаалсан.

Бохирын цооног машин замын ойролцоо байрлах тул бохирыг татаж соруулах зориулалтын машин техник хэрэгсэл хүрч очих боломжтой. Мөн нуурын эргээс 200 м-ээс багагүй зайд байрласан тул ашиглахад бүрэн боломжтой. Мөн Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс дэглэмийг зөрчөөгүй.

## 2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

### 2.1. Төслийн талбай, түүний орчны байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт

#### Физик газарзүйн нөхцөл.

*Уул зүй болон газрын гадарга:* Хөвсгөл нуурын ай сав газар нь уул зүйн хувьд хойгуураа зүүн Соёны уулс, өмнөд хэсгээрээ Хангайн салбар уулс, баруун талаараа Тувагийн уулсын салбар, зүүн талаараа Байгалийн салбар уулсын хооронд шинэхэн газар хөдлөлтөөс үүссэн хонхорт оршдог. Хөвсгөлийн уулсад Улаан тайга, Хорьдол сарьдаг нуруу, Баяны нуруу гэхчилэн голдуу хойноосоо урагш суналттай хэд хэдэн нурууд тогтсон байна.

Хөвсгөл нуурын баруун хэсэг далайн түвшнээс дээш 2500-3500 м өндөр өргөгдсөн эгц хажуу, шовх оройтой өндөр уулсаар хүрээлэгдсэн цавчим хавцал гуу жалгаар хэрчигдсэн байдаг. Харин нуурын зүүн талын хэсэг бэсрэг уулын хэв шинжтэй ихэнх уулсын оргил 2000 м хүрдэггүй, нэлэнхийдээ модоор хучигдсан бөмбөгөр оройтой уулс зонхилно. Зүүн талын уулсын дотроос хамгийн өндөр цэг нь Цагаан уулын оргил 2364 м байдаг. Нуурын зүүн өмнөд хэсэг ихэнхдээ намхан гадаргуутай, нуурын усны түвшнээс дээш 200-400 м өргөгдсөн, хамгийн өндөр цэг нь 700 м орчим өргөгдсөн байдаг. Ай савд хамгийн өндөр цэг нь Мөнх-Сарьдаг уулын оргил Бүрэнхаан (3491 м), хамгийн нам дор газар нь далайн түвшинээс дээш 1645 м-т орших Хөвсгөл нуурын усны мандал юм.

*Физик газарзүйн мужлал:* Хангай-Хэнтийн уулт их мужийн Хөвсгөлийн уулс гэж нэрлэгдэх хэсэгт багтана. Хөвсгөлийн уулархаг нутаг нь гадаргын хувьд Сибирийн геоморфологийн их мужид хамаарах бөгөөд энэ нутгийн физик газарзүйн төрх нь Хойд Азийн эх газарлаг шинжтэй, өмнөд Сибирийн физик газарзүйн бүсэд байрладагт оршино. Хөвсгөлийн уулархаг нутаг нь шинэхэн тектоникийн хувьд Байгаль нуурын хэв шинжийн хотгор, хотостой томоохон морфоструктурын нум хэлбэрийн Алтай-Соён, Дорнод Азийн элементүүдийг тусгасан байдаг.

#### Уур амьсгал.

*Уур амьсгалын онцлог:* Төсөл хэрэгжиж буй Хөвсгөл нуур орчимд манай орны бусад нутгийн нэгэн адил өвлийн улиралд Монголын антициклоны нөлөөнд, дулааны улиралд бага даралттай синоптикийн орны нөлөөнд байдаг (Жамбаажамц, 1992). Уур амьсгалыг бүрэлдүүлэх гол хүчин зүйлс дотроос хамгийн чухал нь газрын гадаргын жигд биш, хотгор гүдгэрийн ялгаа ихтэй байдаг явдал юм. Нутаг дэвсгэрийн хотгор гүдгэрийн ялгаа, гол мөрөн, нуурын нөлөө уур амьсгалын нөхцөлтэй уялддаг.

*Агаарын температур:* Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын агаарын жилийн дундаж температур Хөвсгөл нуурын баруун хэсгээр  $-4-8^{\circ}\text{C}$ , зүүн эрэг болон Эг, Үүрийн голын эхээр  $-4^{\circ}\text{C}$ -аас хүйтэн голын дунд адаг хэсэгт  $-1^{\circ}\text{C}$ -аас дулаан байдаг байна. Нийт нутаг далайн түвшнээс дээш ихээхэн өргөгдсөн учир зун сэрүүн, өвөл хүйтэн. Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын жилд 180-220 орчим хоног агаарын температур хасах хэмтэй байна. Жилийн доторх хуваарилалтын хувьд Монгол орны нийт нутгийн цаг агаарын хуваарилалтын нэгэн адил 1 дүгээр сард хамгийн хүйтэн 7 дүгээр сард хамгийн дулаан байна.

*Хур тунадасны горим, хуваарилалт:* Агаарын чийгшлийн горимыг тодорхойлогч хүчин зүйл нь хур тунадас юм. Намрын анхны цас 10 сарын 1-2 дугаар арав хоногт орж, сүүлийн цас 4 сарын 2 дугаар арав хоногийн дунд үеэр орж хайлдаг буюу жилийн 110-150 хоногт цасан бүрхүүлтэй байдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-25 см хүрнэ. Хөвсгөл нуур-Эгийн голын сав газар 300-450 мм тунадас унана. Тунадасны гуравны нэг нь зөвхөн 7 сард, 70 гаруй хувь нь 6-8 сард, 90 хувь нь 5-6 сард үлдсэн 10 хувийн тунадас өвөл цас хэлбэрээр унана. Хур тунадас их боловч сэрүүн учраас агаарын чийг тийм их биш.

*Агаарын даралт, салхины горим:* Жилийн ерөнхий үүлшилт 5 баллаас үл хэтрэх ба цэлмэг өдрийн тоо, ерөнхий үүлшилтээр 68 болно. Салхины хүч бага, жилийн дундаж хурд 3.2 м/сек бол хамгийн их нь 18-20 м/сек-эс үл хэтрэх бөгөөд уул хөндий, эргийн зэрэг орон нутгийн салхи тодорхой ажиглагдана.

*Уур амьсгалын ирээдүйн хандлага:* Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын уур амьсгал зундаа халуун хуурай, өвөлдөө цас ихтэй байхаар байна гэсэн уур амьсгалын ирээдүйн хандлага ажиглагдаж байна.

*Агаарын чанар.* Агаарын чанарт нөлөөлөх эх үүсвэр нь салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байх бөгөөд агаар бохирдуулах цаг хугацаа болон агаарын бохирдлын хэмжээ, хамрах хүрээгээрээ ялгаатай.

Төслийн газар ашиглах зориулалтын онцлог болон үйл ажиллагаатай холбогдуулан авч үзвэл агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийн хувьд үйл ажиллагаа эхлэх үед гэр сууцын галлагаа болон тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс хаягдах утаа /нүүрстөрөгчийн дутуу исэл, давхар исэл, азотын дутуу исэл, давхар исэл хар тугалга, хүхэрлэг гэх мэт/ байна. Мөн салхи ихтэй үед зам дагууд машин техникийн хөдөлгөөнөөс үүдэн тоосжилт үүсэж агаар дахь том, нарийн ширхэглэгт тоосонцрын агууламж нэмэгдэж болзошгүй. Төсөл хэрэгжиж буй талбайд одоогийн байдлаар агаар дахь түгээмэл тархалттай бохирдуулагч бодис болох хүхэрлэг хий, азотын давхар исэл, тоос, тоосонцрын бохирдолгүй байна.

#### Геологийн тогтоц, геоморфологи.

*Геологийн тогтоц:* Геологийн тогтоцын хувьд нийлмэл гетероген тогтоцтой Тува-Монголын кембрийн өмнөх бөөгнөрлийн төв мужийг эзлэх Сибирийн тавцангийн урд талыг хүрээлэн буй Төв Азийн атриат бүслүүрийн хойт хэсэгт оршино.

*Геоморфологи:* Геоморфологийн хувьд гол, горхийн хөндий, уул нурууд гэсэн 2 үндсэн төрлийн рельефтэй. Геологийн тогтоц нь орчин үеийн дөрөвдөгчийн настай, аллювийн гаралтай хурдсаас эхлээд Рифей, Протерзойн тунамал болон хувирмал чулуулаг хүртэл янз бүрийн насны хурдас чулуулаг тархсан байна.

*Гадаргын ус.* Төсөл хэрэгжиж буй газар нь Монгол орны усны сав газрын ангиллаар 2 дугаар буюу “Хөвсгөл нуур-Эгийн гол”-ын сав газарт багтана.

*Хөвсгөл нуур:* Хөвсгөл нуурт 96 гол, горхи цутгах бөгөөд ганц Эгийн гол эх аван урсдаг. Хөвсгөл нуурын ай сав нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадаргын болон газрын доорх усны хамгийн их нөөц баялагтай нутаг юм. Хөвсгөл нуурын ай савын ус хураах талбай нь 4920 км<sup>2</sup>, тус ай савд голын сүлжээ сайн хөгжсөн, 1 км<sup>2</sup> талбайд 0.43 км голын урт ноогддог, хойноосоо урагшлах тусам голын сүлжээний нягт нь 0.8 км болж буурдаг. Хөвсгөл нуурт хойт талаас Их Хороо, Ханх, зүүн талаас Их Далбаа, Тураг, өмнө талаас Алаг Цар, баруун талаас Жиглэг, өвөр Хачим, Ходон зэрэг томоохон голууд нийлнэ. Голуудын тэжээлийн үндсэн сурвалж нь хур борооны ус бөгөөд 60-80 %-ийг нь эзэлнэ. Цасны ус 5-10 %, үлдэх хэсгийг нь газар доорх урсац тэжээдэг байна.

*Эгийн гол:* Эгийн гол нь 7 дугаар эрэмбийн гол юм. Ус хурах талбай 38354.1 ам км, 509.5 км урт, 0.0016 хэвгийтэй. Голдрилын дундаж өндөр 1140 м, ус хагалбарын

шугамын урт 2545 км, түүний дундаж өндөр 1622.5 м, голуудын нийлбэр урт 13551.3 км, усан сүлжээний нягтшил 0.35 км/ам км, ус хурах талбайн дундаж өндөр 1624.0 м, хөндийн гүн дунджаар 482.5 м, түүний өргөн 75.3 км, сав газрын суналтын зэрэг 6.8, ус хагалбарын шугамын хөгжлийн зэрэг 3.6, хажуугийн хэрчигдэл 1.5, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 3.78, 2.42, 4.529 тус тус байна. Эг голын усны жилийн дундаж өнгөрөлт Хатгал хотын орчим 23.8 шоо м/с байснаа Алаг-Эрдэнэд 9.13 шоо м/с, Эрдэнэбулганд 18.5 шоо м/с хүртэл буурдаг.

Хүснэгт 4. Усны химийн задлан шинжилгээний дүн (Жуулчны баазын ус нөөцлөх сав)

Анион	1 дм <sup>3</sup> -д байгаа			Катион	1 дм <sup>3</sup> -д байгаа		
	мг/экв	мг/л	мг-экв/л		мг/экв	мг/л	мг-экв/л
Cl <sup>-</sup>	42.60	1.20	8.80	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	239.88	10.43	76.49
SO <sub>4</sub> <sup>2-</sup>	0.21	9.85	72.21	NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.20	0.01	0.08
NO <sub>3</sub> <sup>-</sup>	4.25	0.07	0.50	Ca <sup>++</sup>	39.68	1.98	14.52
NO <sub>2</sub> <sup>-</sup>	0.01	0.00	0.00	Mg <sup>++</sup>	14.59	1.20	8.80
CO <sub>3</sub> <sup>2-</sup>	38.40	0.64	4.69	Fe <sup>++</sup>	0.10	0.00	0.03
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	114.72	1.88	13.79	Fe <sup>+++</sup>	0.20	0.01	0.08
<b>Дүн</b>	<b>200.18</b>	<b>13.63</b>	<b>100.00</b>	<b>Дүн</b>	<b>294.65</b>	<b>13.63</b>	<b>100.00</b>

Энэхүү ус нь натри, калийн катион давамгайлсан сульфатын бүлгийн ус гэсэн дүгнэлт гарсан байна.

Хүснэгт 5. Усны химийн задлан шинжилгээний дүн (Хөвсгөл нуурын ус)

Анион	1 дм <sup>3</sup> -д байгаа			Катион	1 дм <sup>3</sup> -д байгаа		
	мг/экв	мг/л	мг-экв/л		мг/экв	мг/л	мг-экв/л
Cl <sup>-</sup>	14.06	0.40	7.91	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	41.19	1.79	35.76
SO <sub>4</sub> <sup>2-</sup>	0.07	3.15	62.92	NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.30	0.02	0.33
NO <sub>3</sub> <sup>-</sup>	3.65	0.06	1.18	Ca <sup>2+</sup>	37.27	1.86	37.15
NO <sub>2</sub> <sup>-</sup>	0.08	0.00	0.03	Mg <sup>2+</sup>	16.29	1.34	26.76
CO <sub>3</sub> <sup>2-</sup>	0.00	0.00	0.00	Fe <sup>2+</sup>	0.00	0.00	0.00
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	85.43	1.40	27.96	Fe <sup>3+</sup>	0.00	0.00	0.00
<b>Дүн</b>	<b>103.28</b>	<b>5.01</b>	<b>100.00</b>	<b>Дүн</b>	<b>95.06</b>	<b>5.01</b>	<b>100.00</b>

Энэхүү ус нь натри, кальци, магни, калийн катион давамгайлсан сульфатын бүлгийн ус гэсэн дүгнэлт гарсан байна.

Газрын доорх ус. Хөвсгөл нуурын ай сав нь ан цав-судлын коллектор бүхий талст чулуулаг зонхилсон, нүх сүвийн коллектор бүхий тунамал сэвсгэр хурдас хязгаарлагдмал тархсан, гидрогеологийн атираат мужид багтдаг. Иймээс ан цавын төрлийн ус элбэг тархсан. Энэ нутгийн газрын доорх усыг чулуулагт оршиж байгаа байршил хөдөлгөөний онцлогоор нь:

а) Дөрөвдөгчийн настай сэвсгэр хурдсын нүх сүвийн ус

б) Неоген-дөрөвдөгчийн хүрмэн чулуу, кемберийн өмнөх хувирмал чулуулаг, янз бүрийн настай гүний чулуулгийн ан цавын ус гэж хоёр төрөлд хувааж үзэж болно (Батсүх Н, 1995)

Дөрөвдөгчийн настай сэвсгэр хурдастай нүх сүвийн ус нь элс, хайрга, дайрга, чулуун асга, асарганд хуримтлагдах бөгөөд бага гүнд оршино. Их-Хороо, Баян голуудын хөндий, Хатгал орчмоор 0.3-5.0 м гүнд илэрнэ. Бага гүнд орших учраас тэр хавийн газар намагжих жижиг булаг байдлаар газрын гадаргад илрэх нь олонтой. Жаргалант, Мунгараг, Сэвсүүл, Шигнүүл голын хөндийгөөр ийм баримт элбэг бий. Нүх сүвийн ус нь хур тунадас гадаргын усаар тэжээгддэг. Агуулах чулуулгийн гарал үүслээр нь аллювийн, делюви-пролювийн, мөстлөгийн ба элювийн хурдсын ус гэж ангилж хувааж үздэг (Батсүх Н, 1995).

Хөрсөн бүрхэвч.

*Хөрсний тархалт:* Хөвсгөл нуур-Эгийн голын сав газар хөрс газарзүйн Хөвсгөлийн их мужийн Хөвсгөлийн баруун ба зүүн тойрог болон Хангайн их мужийн Сэлэнгийн тойрогт хамрагдана. Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын хувьд ихэнх хэсгийг нь уулын тайгын ширээт төмрийн исэлтэй хөрс тархсан бөгөөд голын эхэн хэсэгт уулын тайгын цэвдэгт ухаа шороон болон уулын хар шороон карбонатгүй хөрс алаг цоог байдлаар тархсан байна. Сав газрын адаг хэсгээр уулын нугын хөрс багахан хувийг эзэлсэн байна.

*Хөрсний элэгдэл, эвдрэл:* Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын Хөвсгөл нуурын баруун хэсгийн хөрс цас мөс, мөнх цэвдгийн нөлөөгөөр эвдрэх ихээхэн эрсдэлтэй юм. Харин голын сав газрын дээд болон дунд хэсгийн хөрс хур борооны үер болон хажуугийн урсацын нөлөөлөлд орж эвдрэх эрсдэл багатай байдаг. Мөн сав газрын 50-иас дээш хувь нь ойгоор бүрхэгдсэн учир голын эхэн болон дунд хэсгийн хөрс салхинд эвдрэх эрсдэл бага. Харин Эгийн голын нуураас эх авсан хэсгээс доошхи хэсэгхэн газрын хөрс салхинд эвдрэх эрсдэл дунд байна.

*Хөрсний агрохимийн болон физик механикийн шинж чанар:* “Гурван-Эрдэнэ” жуулчны баазын талбайд 2 цэгт хөрсний зүсэлт хийж дээжийг “Инженер Геодези” ХХК-ийн лабораторт хүргүүлэн шинжлүүлсэн үр дүнгээс

Хүснэгт 6. Хөрсний агрохимийн үзүүлэлт

Дээжний нэр	pH	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	Давс, %	NO <sub>3</sub> , %	CO <sub>2</sub>	Солилцох суурь, мг-экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр		
							Ca+Mg	Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O	
Зүсэлт-1	7.4	0.215	5.24	0.07	6.97	2.67	39.5	26.3	12.2	4.0	18	
Зүсэлт-2	8.1	0.403	2.99	0.09	1.25	2.58	31.9	18.7	13.2	1.2	9	

Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж авсан цэгийн координат	Ширхэгийн хэмжээ, % ( мм-ээр)		
	Элс (1-0.05 мм)	Тоос (0.05-0.01 мм)	Шавар (< 0.01 мм)
50°43'34.94", 100°14'43.86"	50.0	12.5	37.5
50°43'34.94", 100°14'43.86"	34.6	41.7	23.7

Ургамлан нөмрөг. Ургамал-газарзүйн мужлалтаар манай “Гурван-Эрдэнэ” жуулчны баазын талбай нь Евразийн шилтүүст ой, нугат хээрийн их мужийн Алтай-саяны мужийн хүрээнд Улаан тайга-Хорьдол сарьдагийн тойрогт хамаарагдаж байна (Монголын үндэсний атлас, 2008 он). Хөвсгөл орчимд 69 овог, 262 төрөлд хамаарах 750 зүйл дээд ургамал тэмдэглэгджээ /Ц.Жамсран, Л.И.Малышев/. Эдгээрийн 18 зүйл нь цоргот, 7 зүйл нь нүцгэн үрт, 725 зүйл нь бүрхүүл үрт ургамал юм. Хөвсгөл нуурын эргэн тойронд 200 гаруй эмийн болон ашигт ургамал байдгаас эмийн ургамал 169 зүйл, хүнсний ургамал 35 зүйл, тэжээлийн ургамал 6 зүйл, техникийн ургамал 32 зүйл, гоёл чимэглэлийн ургамал 31 зүйл, ус цэвэрлэгч ургамал 8 зүйл байна. Энэ бүс нутагт нэн ховор, ховор ургамал болох вансэмбэрүү, монгол хундага, алтайн сонгино, жамъяанмядаг, сараана /төмсний улаан/, монгол хунчир зэрэг ургамлууд ургадаг.

Ойн сан. Хөвсгөлийн БЦГ-ын хувьд сибирь хушин ой (*Pinus sibirica*), шинэсэн ой (*Larix sibirica*), улиангарын ойн формациудаас бүрддэг. Хушин ой уулын оргил, дээд биеэр, дангаараа буюу шинэстэй холилдон байрлана. Уулын дээд, дунд биеэр д.т.д 1900-2000 м өндөрт хуш шинэсэн ой зонхилно. Бүх ойтой талбайн тавны дөрвийг шинэсэн ой эзлэх ба д.т.д 1645-2300м хүртэл ургана. Улиангарын ой хад асгатай, энгэр хажуу, чулуурхаг ан хавцалд хэсэг хэсэг төгөл үүсгэж байрлана. “Гурван-Эрдэнэ” жуулчны бааз нь Хөвсгөл нуурын эрэг дагуух ойн сангийн захад буюу ашиглаж буй талбайн баруун захаар нэлээд ойрхон хил залгаа шинэсэн ой байна.

Ойн ургамалжилт: Уулын тайгархаг ойн бүслүүрт д.т.д-ш 1500-1800 м өндөрт тайгын ширэгжүү хөрсөнд тархсан элдэв өвс-улалжит, үетэн элдэв өвст, ашиглаж хамгаалвал зохих Шинэсэн ой зонхилно. Уулын дээд хэсгийн цармын бүслүүрт тархан ургасан модод нь намхан, сийрэг, өвслөг нөмрөг багатай голчлон хөвд, сөөг, сөөгөнцөр ургамлууд тархсан байдаг бол харин уулын дунд хэсгээс доош модод нь өндөр, өтгөрөл ихтэй, өвслөг нөмрөгөөр баялаг болно.

#### Амьтны аймаг.

Хөхтөн амьтад: Хөвсгөлийн БЦГ-ын орчимд 63 зүйл хөхтөн амьтад байршин амьдардаг байна. Үүнээс туруутнаас 4 овгийн 7 төрөлд хамаарах 7 зүйл, туулайтнаас 2 овгийн 2 төрөлд хамаарах 4 зүйл, мэрэгчдээс 5 овгийн 14 төрөлд хамаарах 23 зүйл, махчдаас 4 овгийн 11 төрөлд хамаарах 17 зүйл байршдаг байна. Хөвсгөлийн БЦГ харьцангуй олон янзын амьдрах орчинтойгоос хамааран амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүн олон бөгөөд нэлээд хэдэн зүйл ховор болон нэн ховор хөхтөн амьтны зүйл байдаг. Хөвсгөл нуур орчмын хөхтөн амьтдын олонхи нь Сибирийн тайгын болон сэрүүн бүсийн амьтад юм. Хөвсгөл нуурын ай савд Монголын Улаан номд орсон нэн ховор амьтан болох баданга хүдэр, зэрлэг цаа буга, ховор амьтан болох хүрэн баавгай, халиун буга, янгир ямаа, сибирь хандгай, ойн булга зэрэг хөхтөн амьтад амьдардаг. Мөн умардын халиу, бор гөрөөс, зэрлэг гахай, нохой зээх, Монгол тарвага, чандага, саарал чоно, шар үнэг, хярс, мануул, дорго, зурам, хэрэм, солонго, цагаан үе, өмхий хүрэн, шилүүс, алаг даага зэрэг амьтад тархсан байдаг. Тус нутагт Баданга хүдэр, Халиун буга, Хандгай, Хүрэн баавгай, Зэрлэг цаа буга зэрэг ховор, ховордсон амьтад байршдаг. Хөхтөн амьтдын 9.5% нь Монгол Улсын “Амьтны тухай” хуулиар “нэн ховор” 7.9% нь Засгийн газрын тогтоолоор “ховор” гэж үнэлэгдсэн байна.

Усны амьтан: Хөвсгөл нуур, түүний цутгал гол, горхинд нийт 9 зүйл загас байдаг. Үүнээс хадран, зэвэг, гутаарь, омуль, алгана, улаан нүдэн зэрэг 6 зүйл нь агнуурын ач холбогдолтой. Агнуурын ач холбогдолгүй 3 зүйл загас байдаг. Сахалт жараахай, Барлан, Чимхүүрт загас байна. Хөвсгөл нуурын усанд 69 зүйл планктон амьтан амьдардгаас сэлүүр хөлт хавч 10, салаа сахалт хавч 19, хүрд хорхой 30 зүйл бий. Нуурын 0-5 метрийн гүнд планктон амьтны зүйлийн бүрэлдэхүүний 80 хувь амьдардаг. 8 дугаар сард планктон амьтны үржил, хөгжил хамгийн дээд хэмжээндээ хүрч энэ үед биомасс нь 39.62 мг/м<sup>3</sup> болно. Хөвсгөл нуурт 15 овогт багтах 200 шахам зүйлийн ёроолын амьтан байна. Дундаж биомасс нь 1.2 г/м<sup>2</sup>, үүний дотор гаммарид 83.3 хувь хоовгон, турбуллари, дугариг хорхой, мермитед, усны хачиг, мөхөөлж, хаваржин шавж эзэлдэг. Ёроолын амьтад нь загасны гол тэжээл болдог.

Жигүүртэн: Энэ бүс нутагт 286 зүйлийн шувууд өндөр уулын, ойн, ойт хээрийн, ус намгийн зэрэг янз бүрийн ландшафт, амьдрах орчноо түшиглэн түр болон байнга оршин амьдардаг байна. Эдгээрээс “Монголын улаан ном”-нд орсон цэвэр усны эндемик амьтан цагаан сүүлт бүргэд, явлаг сар, гангар хун зэрэг 7 зүйл нэн ховор шувуу, ЗГ-ын тогтоолоор батлагдсан 9 зүйл ховор шувуу, СИТЕS-ийн хавсралтанд бүртгэгдсэн 41 зүйл нэн ховор, ховор шувуу байна.

Манай жуулчны бааз байрлах 2.23 га талбайд томоохон хөхтөн амьтан байхгүй зөвхөн хөрсний микроорганизм, түүний ойр орчимд ойн шувууд жижиг мэрэгч амьтад үзэгдэнэ.

2.2. Төслийн талбай, түүний орчны нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт<sup>1</sup>

**Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 11 сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга**

Хөдөлмөр эрхлэлт. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажил хайгч 2022 оны 11 дүгээр сарын эцэст 852 иргэн байгаагийн 398 нь эмэгтэйчүүд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс ажил хайгч 145 иргэн буюу 20.5 хувиар, эмэгтэйчүүд 47 иргэн буюу 13.4 хувиар тус тус өссөн байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 73.1 хувийг бүрэн дунд, 16.1 хувийг дипломын болон бакалаврын, 3.8 хувийг суурь, 2.2 хувийг боловсролгүй, 1.8 хувийг техникийн болон мэргэжлийн, 1.6 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.3 хувийг бага, 0.1 хувийг магистр, насны бүлгээр авч үзвэл 31.5 хувийг 15-24 насны, 30.2 хувийг 25-34 насны 21.2 хувийг 35-44 насны, 14.4 хувийг 45-54 насны, 1.4 хувийг 60-аас дээш насны, 1.3 хувийг 55-59 насны иргэд эзэлж байна. Ажлын байрны захиалга 2022 оны эхний 11 сарын байдлаар 1550 бүртгэгдэж, ажилд зуучилсан 927 иргэн байгаагийн 463 нь эмэгтэй байна.

Нэгдсэн төсөв. 2022 оны эхний 11 сарын байдлаар аймгийн төсвийн орлого 60.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс орлого 52.8 (46.8%) тэрбум төгрөгөөр, зарлага 47.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 48.2 (50.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны эхний 11 сарын байдлаар 323.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь сарын эцэст 1.8 хувь болсон нь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өссөн байна. 2022 оны эхний 11 сарын байдлаар аймгийн татварын орлого 29.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.0 (20.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн даатгал. Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2022 оны эхний 11 сарын байдлаар 29031.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3.5 хувь буюу 993.0 сая төгрөгөөр өссөн байна.

Мөнгө, зээл. Төгрөгийн хадгаламж 2022 оны эхний 11 сарын байдлаар 181.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.6 хувь буюу 1.0 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 17.8 хувь буюу 39.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Төгрөгийн хадгаламжийн 99.9 хувь нь иргэдийн хадгаламж, 0.1 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж байна.

Эрүүл мэнд.

Төрөлт: Хөвсгөл аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар 2 089 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 383 (15.5%), нийт 2 096 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 382 (15.4%) тохиолдлоор тус тус буурсан байна.

Нялхасын эндэгдэл: Хөвсгөл аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 34 тохиолдол бүртгэгдсэн нь 2021 оны мөн үеэс 2 (5.6%) тохиолдлоор буурсан байна. Нялхасын эндэгдлийн 17 (50.0%) тохиолдлыг нярайн эндэлдэл эзэлж байна.

<sup>1</sup> Эх сурвалж: <https://khuvsgul.nso.mn>

*1-5 нас хүртэлх хүүхдийн эндэгдэл:* 2022 оны эхний 11 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдлоор буурсан байна.

*Нас баралтын үзүүлэлт:* 2022 оны эхний 11 сарын байдлаар нас баралтын 712 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 27 (3.7%) тохиолдолоор буурсан байна. Нийт нас баралтын 157 (22.1%) тохиолдол нь эмнэлэгт нас барсан байна. Осол гэмтлийн нас баралтын 114 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 19 (20.0%) тохиолдолоор өссөн ба нийт нас баралтын 16.0 хувийг, хорт хавдрын нас баралт 179 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 14 (8.5%) тохиолдлоор өссөн ба нийт нас баралтын 25.1 хувийг эзэлж байна.

*Халдварт өвчин:* Хөвсгөлийн аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 5 494 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь 2021 оны мөн үеэс 13 370 тохиолдол буюу 3.4 дахин буурсан байна. Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 17.9 хувь, сүрьеэ 1.2 хувь, амьсгалын замын өвчин 1.3 хувь, цусан халдвар 0.1 хувь, гэдэсний халдварт өвчин 0.8 хувь, арьс салстаар халдварлах халдвар 0.1 хувь, зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчин 0.3 хувь, Ковид-19 халдвар 78.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний 987 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 401 (68.4%) тохиолдлоор өссөн байна. Нийт БЗХӨ-нөөс тэмбүү 145 (14.7%) тохиолдол, трихомониаз 64 (6.6%) тохиолдол, гоноккок халдвар 777 (78.7%) тохиолдлыг тус тус эзэлж байна.

*Гэмт хэрэг.* Хөвсгөл аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 809 гэмт хэрэг бүртгэгдэж 726 хүн холбогдсон байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад гэмт хэрэг 137 (20.4%) тохиолдол, гэмт хэрэгт холбогдогчид өнгөрсөн оны мөн үеэс 110 (17.9%) тохиолдлоор тус тус өссөн байна. Гэмт хэргийн улмаас хохирсон 852 иргэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 167 (24.4%) хүнээр өссөн байна. Нийт хохирсон иргэдийн 491 (57.6%) хүн нь эмэгтэйчүүд байна. Энэ оны 11 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн хувьд согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 213, галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 2, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 45, насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэрэг 18, эмэгтэй хүн оролцсон хэрэг 65 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 38 (21.7%) тохиолдлоор өссөн байна. Гэмт хэргийн улмаас 2022 оны 11 сарын байдлаар нас барсан 36 хүн, гэмтсэн 270 хүн бүртгэгдсэн ба нас барсан хүн өмнөх оны мөн үеэс 15 (71.4%), гэмтсэн хүн 2021 оны мөн үеэс 56 (26.2%) тохиолдлоор тус тус өссөн байна. 2022 оны эхний 11 сарын байдлаар 23 730 захиргааны зөрчил гарч, өмнөх оноос 1 445 (6.5%) тохиолдлоор өссөн байна. Мөн энэ онд 439 хүн баривчлагдаж, 407 хүн эрүүлжүүлэгдэн, 22 227 иргэнийг торгон нийт 1 065.1 сая төгрөгний торгууль ногдуулсан байна.

*Аж үйлдвэр.* Аж үйлдвэрийн газрууд 2022 оны эхний 11 сард 32.6 тэрбум төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 35.6 тэрбум төгрөгний бүтээгдэхүүн борлуулав. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс 17.7 хувь, бүтээгдэхүүний борлуулалт 15.9 хувиар тус тус өссөн байна.

### **3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт**

Жуулчны баазын үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, агаар, усан орчинд дараах гол сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:



- Хөрсөн бүрхэвчийн элэгдэл
- Ус ашиглалтын байдлаас усны чанар нөлөөлөх (гадаргын ус)
- Газар ашиглалтаас эдэлбэр газар доройтох
- Агаарын чанарын өөрчлөлт (тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс орчны агаарт тоосжилт үүсэх, агаарт түгээмэл тархацтай бохирдуулагч бодис CO, NO<sub>2</sub>, SO<sub>2</sub> ялгарах, агаар дах бохирдуулагч бодисын агууламж нэмэгдэх)
- Ургамлан нөмрөг талхлагдах, зүйлийн олон янз байдал өөрчлөгдөх

Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөллийг сөрөг (х), эерэг (+), нөлөөлөлгүй (0) гэсэн 3 бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг бага зэрэг, дунд зэрэг, хүчтэй гэсэн 3 зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлэн доорх хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 8. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Чиглэл		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
<b>1. Байгалийн экосистемийн өөрчлөлт</b>											
Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Агаарын төлөв байдал	х	х		х					х		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х	х				х			х		
Геологийн тогтоцын өөрчлөлт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Зэрлэг амьтдын орон зайн тархалтын өөрчлөлт		х				х			х		
Бичил уур амьсгалын өөрчлөлт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>2. Байгалийн нөөц ашиглалт</b>											
Газар ашиглалт	х					х				х	
Цэнгэг усны нөөцийг ашиглах /ус ашиглалт/	х					х			х		
Ойн сан	х	х				х			х		
Түгээмэл тархацтай ашигт малтмал (мод, өнгөт чулуу)	х	х				х			х		
Байгалийн сэргээгдэх эрчим хүч	х					х			х		
<b>3. Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>											
Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх		х				х			х		



Эерэг нөлөөлөл (+)	5	3	0	0	0	6	0	0	6	0	0
Нийт дүн	26	25	8	10	8	31	8	8	31	9	9
Нийт хувь	78. 7	75. 7	24. 2	30. 3	24. 2	93. 9	24. 2	24. 2	93. 9	27. 2	27. 2

Дээрх “Магадлан Жагсаах Матрицын арга”-аар тодорхойлсон болзошгүй сөрөг нөлөөллийн ихэнх нь нөлөөллийн хэлбэрийн хувьд шууд, хугацааны хувьд урт, нөлөөллийн эрчмийн хувьд бага зэрэг байна. Мөн хүний буруутай үйл ажиллагааны улмаас осол аваар гарах, аюулт үзэгдлийн нөлөөгөөр үүсэх болзошгүй сөрөг нөлөөлөл байна. Тухайлбал:

- Аянга цахилгаан
- Газар хөдлөлт
- Усан замын тээврийн үеийн осол аваар
- Объектын болон ойн түймэр
- Морь малнаас унах гэх мэт нөлөөлөл үүсэж болзошгүй.

Аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанаас томоохон хөхтөн амьтан, түүх, соёлын дурсгалт зүйлд шууд байдлаар нөлөөлөл үзүүлэхгүй. Эдгээрт зөвхөн шууд бус байдлаар урт хугацаанд нөлөөлөл үзүүлнэ.

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн орчны бүсийн иргэдийн нийгмийн байдалд олон талын ач холбогдолтой байна гэж үзэж байна. Тухайлбал:

- Ажилгүйдлийн тоо буурах
- Ажлын байр бий болох
- Амьжиргааны түвшин дээшлэх
- Өрхийн орлого нэмэгдэх
- Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- Татварын орлого нэмэгдэх
- Орчны дэд бүтцийн байдал сайжрах
- Татварын орлогоор дамжин улсын төсөв хуримтлагдах мөнгөн дүн нэмэгдэх зэрэг болно.

#### 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

“Гурван-Эрдэнэ” аялал жуулчлалын баазын үйл ажиллагааны явцад бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, биелэлтийг дүгнүүлэн ажиллах

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаа. Үүнд:

- 1) Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг байгалийн бүрэлдэхүүн тус бүрээр (газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, агаар орчин, усан орчин) боловсруулах
- 2) Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулах
- 3) Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах
- 4) Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх

Байгаль орчны удирдлагын тогтолцоо

- Байгаль орчны төлөвлөлт
  - Хэрэгжүүлэлт, гүйцэтгэл
  - Хяналт шалгалт
  - Удирдлагын сайжруулалт гэсэн 4 үндсэн бүрэлдэхүүнтэй байна.
- 5) Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг төлөвлөх
- 6) Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах хуваарь зэргийг тус тус тусгах

## 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Жуулчны баазын үйл ажиллагааны явцад орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг байгалийн бүрэлдэхүүн тус бүрээр тодорхойлон доорх хүснэгтэд нэгтгэн үзүүлсэн болно.

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Газрын гадарга, хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх	Газар ашиглах тухай гэрээний хэрэгжилтийг Хөвсгөлийн УТХГ-ын Хамгаалалтын захиргаа, Алаг-Эрдэнэ сумын Засаг даргаар хяналтын хуудсаар дүгнүүлэх	Гэрээгээр ашиглаж буй 2.23 га газар	га	150000	1	333164	жилд 1 удаа жилийн эцсээр 12-р сард багтаана	Газрын тухай хууль УТХГНД-т газар ашиглах тухай гэрээ
2.	Хөрсөн бүрхэвч, газрын гадарга бохирдох	Жуулчны баазын хамгаалалтын бүс болох Хөцөө хашааны гадна доторх талбай, нуурын эрэг дагуух хог хаягдлыг цэвэрлэх	Жуулчны баазын ойр орчин, нуурын эрэг дагуу	удаа	-	7 хоногт 1 удаа	-	2023 он үйл ажиллагааны явцад	Хог хаягдлын тухай хууль
3.	Агаар болон хөрсний бохирдол үүсэх	Халдваргүйжүүлэлт хийлгэх гэрээг шинэчлэн байгуулах	Жуулчны баазын объект 120 м <sup>2</sup>	удаа	Үйл ажиллагааны зардал	1	Үйл ажиллагааны зардал	2023 он, үйл ажиллагаа эхлэхийн өмнө	18/325 дугаар гэрээ
4.		Халдваргүйжүүлэлт, ахуйн шавж, мэрэгч устгалыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх	Жуулчны баазын объект 120 м <sup>2</sup>	м <sup>2</sup>	1 м <sup>2</sup> тутамд тус бүр 400 төгрөг	Шавжгүйтгэл-1 удаа Мэрэгчгүйтгэл-1 удаа	96000	2023 он 6-7 сард, 1 удаа	18/325 дугаар гэрээ

5.	<b>Агаар орчин, газрын доорх ус бохирдох</b>	Бохир усны цооногийг соруулж зайлуулах, хяналтын хуудсаар баталгаажуулах	Жуулчны баазын талбай дах бохирын цооног	удаа	1 удаа=200000 төгрөг	Тухай бүр ЖБ-ын ачааллаас хамаарна.	Үйл ажиллагааны зардал	2023 он үйл ажиллагааны явцад	БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан 2018.04.05 өдрийн А/82/128 тоот журам Бохир ус зайлуулах №19/01 дугаар гэрээ
6.	<b>Усны нөөц багасах</b>	Ус ашиглах гэрээний дагуу усны төлбөрийг бүрэн төлж барагдуулах	Жуулчны бааз	шоо метр	112840	19.2 м <sup>3</sup>	112840	2023 он жилд 1 удаа	2022 оны 07 сарын 19 өдрийн 01 дугаар Ус ашиглах гэрээ
7.		Ус бохирдуулсны төлбөр хураамжийг төлж барагдуулах	Төслийн талбай	удаа	86400	1	86400	2023 он жилд 1 удаа	2022 оны 05 сарын 20-ны өдрийн 01 дугаар гэрээ
8.	<b>Газрын доорх болон гадаргын ус бохирдох</b>	Цэвэр ус нөөцлөх савыг угааж цэвэрлэх, ариутгах	Ус нөөлөх сав	удаа	-	7 хоног тутам	--	2023 он үйл ажиллагаа эхлэхийн өмнө	-
9.		Шугам хоолойн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийх	Цэвэр, бохир усны шугам сүлжээ	удаа	-	2	-	2023 он үйл ажиллагаа эхлэхийн өмнө	-
	<b>Нийт зардал, төг</b>		-	-	<b>549640</b>	-	<b>628404</b>	-	-

6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	<b>Төслийн талбай, түүний орчны орчны өнгө үзэмж доройтох</b>	Орчны тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх	Санамж, тэмдэг тэмдэглэгээ	ш	3-5	50000	250000	2023 он Үйл ажиллагааны явцад	-
2.		Онгологийн сайрын хогийг цэвэрлэх, зайлуулах	Онгологийн сайр	удаа	1	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллага аны зардал	2023 он Үйл ажиллагааны явцад	-
3.		Нуур луу машин орох дүмбийг сэргээн засварлах	Нуурын эрэг	удаа	1	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллага аны зардал	2023 он Үйл ажиллагааны явцад	-
4.		Явган замыг модоор тохижуулах	Явган зам	м	200-300	100000	100000	2023 он Үйл ажиллагааны явцад	-
5.		Хоолны заалны талбайг өргөтгөх	Ресторан	удаа	1	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллага аны зардал	2023 он Үйл ажиллагаа эхлэхийн өмнө	-
<b>Нийт зардал, төг</b>			-	-	-	<b>150000</b>	<b>350000</b>	-	-

## 7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжиж буй 2.23 га талбайд түүх, соёлын биет өв байхгүй тул “Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулах шаардлагагүй гэж үзлээ. Манай Хөвсгөлгеологи ХК нь Хөвсгөл нуур, Хөвсгөл аймгийн түүх, соёлын биет өв, байгалийн сайханг түшиглан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд үзүүлж буй тул орон нутгийн соёлын биет болон биет бус өвийг сурталчилан таниулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, аялагч, жуулчдад үнэн зөв мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн хүрээнд ажиллахыг зорьдог.

## 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, т өг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн хаягдал	Хог хаягдал зайлуулах гэрээний дагуу хог хаягдлыг зайлуулах, хяналтын хуудсаар баталгаажуулах	Жуулчны бааз, болон ойр орчны хатуу хог хаягдал	удаа	1 удаагийн хог ачилт 120000	5	600000	2023 он Хог ачилт хийх бүр	Хог хаягдлын тухай хууль Хог хаягдлын бүртгэл хөтлөх, тайлагнах журам
		Ахуйн хог хаягдлыг 3-4 төрлөөр ангилан ялгах	Хатуу хог хаягдал	төрөл	-	3-4	-	2023 он Үйл ажиллагааны явцад	Хог хаягдлын тухай хууль
		Дахивар хог (шил, хуванцар) 2-догч түүхий эд цуглуулдаг эрх бүхий этгээдэд нийлүүлэх	Дахивар хог (шил, хуванцар сав гэх мэт)	удаа	-	Тухай бүр	-	2023 он Үйл ажилалгааны явцад	Хог хаягдлын тухай хууль



		Бохир усны цооногийг соруулж зайлуулах, хяналтын хуудсаар баталгаажуулах	Жуулчны баазын талбай дах бохирын цооног	удаа	1 удаа=2000 00 төгрөг <sup>2</sup>	Тухай бүр ЖБ-ын ачааллаас хамаарна	Үйл ажиллагааны зардал	2023 он үйл ажиллагааны явцад	БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан 2018.04.05 өдрийн А/82/128 тоот журам Бохир ус зайлуулах №19/01 дугаар гэрээ
2.	Аюултай хаягдал	Хуруу зай/Батерей-г зориулалтын саванд цуглуулж, БОАЖЯ-ны харьяа Цэнгэг Ус Байгаль хамгаалах төвд тушаах	Рестораны барилгад	ш	100000	1	100000	2023 он Үйл ажиллагаа эхлэхийн өмнө	Хог хаягдлын тухай хууль
	<b>Нийт зардал, төг</b>		-	-	<b>220000</b>	-	<b>700000</b>	-	-

### 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Энэхүү төлөвлөгөөнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд (хөрсний физик, химийн шинж чанар, усны чанар, бохирдол) тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг тодорхойлон тусгасан болно.

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
---	-----------------------------------	-------------------------	--------------------	----------------	---------------------	------------------	---------	------------------------------------

<sup>2</sup> Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд тугагдсан тул энэхүү “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-ний зардалд ороогүй болно.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэр,  
Хөвсгөлийн БЦГ-ын Онгологийн цагаан дэнж нэртэй  
газарт байрлах “Гурван-Эрдэнэ” аялал жуулчлалын бааз

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

	1	2	3	4	5	6	7	8
1.	<b>Хөрсний хими, физикийн үзүүлэлт- Агрохимийн шинжилгээ</b>	Ариун цэврийн байгууламжийн бохирын цооногийн орчинд 50°43'34.94"/100°14'43.86"	2023 он 7-8 сард	1	30000	30000	Хөвсгөл аймгийн УЦУОШГ-ын БОШЛабораторитой хамтран ажиллана.	MNS 5668-06 MNS 4697-98 MNS 9694-1998
2.	<b>Ундны усны бүрэн шинжилгээ</b>	Ус нөөцлөх савнаас 50°43'36.35"/100°14'43.48"	2023 он 6 сард	1	45000	45000		MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
	<b>Нийт зардал, төг</b>	-	-	-	<b>75000</b>	<b>75000</b>	-	-



*Зураг 22. Дээжлэлт хийх цэгийн байршил*

### 10. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчны удирдлагын тогтолцооны гол зорилго нь төслөөс байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг урьдчилан илрүүлж түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах ба хянахад чиглэсэн байх ба *байгаль орчны бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шалгалт хийх, удирдлагын дүн шинжилгээ хийх* гэсэн таван үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд энэ нь байгаль орчны үзүүлэлтийг тасралтгүй сайжруулах ач холбогдолтой.

Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			6-р сар	7-р сар	8-р сар		
	1	2	3	4	5	6	7
1.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих	Төсөвлөгдсөн санхүү	Үйл ажиллагааны үед			Жуулчны менежер	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
2.	Байгууллагын дотоод журмыг сайжруулах, дотоод хяналтыг сайжруулах	-	Тасралтгүй сайжруулах			Жуулчны баазын менежер	Батлагдсан дотоод журамд
3.	Жуулчны баазын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг сайжруулах, ажилчдыг хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллуулах	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны үед			Жуулчны баазын менежер, ЦЭЭГ ХХК-ийн хүний нөөцийн менежер	Хуулийн хүрээнд ажил үйлчилгээ явуулах
4.	Хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны үед			Жуулчны баазын удирдлага	Хүлэмж ашиглаж байгаа
5.	Үйл ажиллагааны оргил ачааллын үед Сайн дурын байгаль хамгаалагч ажиллуулах, Өөрийн ажилчдаас эргүүл пост гаргах	200000	Үйл ажиллагааны үед				
6.	Орон нутагт хандив, мөнгөн тусламж үзүүлж хамтран ажиллах	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны үед			ЦЭЭГ ХХК-ийн удирдлага	Баяр наадам, тэмдэглэлт баяр арга хэмжээнд
7.	Ус бохирдуулсны төлбөрийн гэрээг сунгах	-				ЦЭЭГ ХХК-ийн удирдлага	
	<b>Нийт зардал, төг</b>	<b>200000</b>	-	-	-	-	-

## 11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах хуваарь

Хүснэгт 14. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Хөвсгөл аймгийн БОАЖГ	БОМТ-ний биелэлтийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлнэ.	<i>Тухайн жилийн БОМТ-г БОНХ-ийн сайдын 2019.10.29-ний өдрийн А/618 тоот тушаалын 3-р хавсралтаар батлагдсан БОМТ-ний биелэлтийг тайлагнах агуулгыг хамруулна.</i>	11-р сарын 01-ний дотор	-	ЦЭЭГ ХХК-ийн захирал, жуулчны баазын менежер, хариуцсан албан тушаалтан	Хөвсгөл аймаг, Мөрөн ЗДТГ
2.	Хөвсгөл аймгийн ЗД-ын томилсон ажлын хэсэг <sup>3</sup>	Газар дээр нь дүгнэнэ.		11 дүгээр сарын 30-ны дотор	Үйл ажиллагааны зардал	ЦЭЭГ ХХК-ийн удирдлага, төлөөлөл	Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум, Гурван-Эрдэнэ жуулчны бааз
3.	Ерөнхий үнэлгээ хийсэн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БОАЖЯ)	БОМТ-ний биелэлтийн талаар тайлан болон дараа жилийн БОМТөлөвлөгөөг цахим хэлбэрээр хүргүүлнэ.		12-р сард багтаах /үйл ажиллагаа эхлэхийн өмнө/	Үйл ажиллагааны зардал	ЦЭЭГ ХХК-ийн захирал, жуулчны баазын менежер	Улаанбаатар хот БОАЖЯ
	<b>Нийт зардал, төг</b>	-	-	-	<b>Үйл ажиллагааны зардал</b>	-	-

<sup>3</sup> Ажлын хэсэгт аймаг, ... байгаль орчны газрын дарга, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны асуудал хариуцсан улсын байцаагч, сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн, сум, ... байгаль орчны хяналтын улсын байцаагч, тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч, нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл орно. А/618 журмын 4.4-т

ЦЭЭГ ХХК-ийн Гурван-Эрдэнэ жуулчны баазын 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр)-нд нийт **1953404 төгрөг (Нэг сая есөн зуун тавин гурван мянга дөрвөн зуун дөрвөн төгрөг)** зарцуулагдана.

*Хүснэгт 15. 2022 оны БОМТ-нд зарцуулагдах нийт зардал, төгрөг*

Д/д	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулга	Нийт зардал, төгрөг
1.	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	628404
2.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	350000
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээнийн төлөвлөгөө	-
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	700000
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	75000
9.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгууллалтын төлөвлөгөө	200000
10.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах хуваарь	Үйл ажиллагааны зардал
<b>Нийт зардал, төг</b>		<b>1953404</b>